



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН СОЁЛЫН
ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/02

Цэнхэрмандал сум

Эд хөрөнгийн тооллого явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2, 70.3, 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 238 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2026 оны 143 дугаар тогтоол, Хэнтий аймгийн засаг даргын 2026 оны А/245 тоот захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын 2026 оны улсын тооллого болон эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллогыг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 2026 оны 07 дугаар сарын 09-ны өдрийг дуустал хугацаанд зохион байгуулсугай.

2. Байгууллагын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Үүнд: Ажлын хэсгийн ахлагч: Н.Ганзул - Бүжгийн багш

Нарийн бичгийн дарга: Д.Оюунбаяр - Нягтлан бодогч

Гишүүн: Л.Энхнас - Номын санч

3. Комисст эд хөрөнгийн тооллогыг холбогдох хууль тогтоомж, журамд нийцүүлэн зохион байгуулж, эд хөрөнгийг биетээр нь тулган тоолж, бүртгэлийн мэдээтэй тулган шалгаж, тооллогын дүнгийн тайлан, мэдээг 2026 оны 06 дугаар сарын 19-ны өдөр холбогдох байгууллага, даргад танилцуулахыг үүрэг болгосугай.

ДАРГЫГ ТҮР

ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.БААТАРДОРЖ

